

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Дугаар 01/2025

2025-04-21

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны үр
дүн, 2025 оны үндсэн зорилтын тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон 2025 оны үндсэн зорилт, үзүүлэлтүүдийн тухай хэлэлцсэн, хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын хураалтын үр дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны үр дүнг тайлангаар хүлээн зөвшөөрсүгэй.

2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг дараахь байдлаар тогтоон баталсугай.

- Үйлдвэрлэл	53000 м2
- Борлуулалт	7 100 000,0 мян. төг
- Хөрөнгө оруулалт	1 600 000,0 мян. төг
- Цэвэр ашиг	1 185 000,0 мян. төг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	104 000 төг/м2

3. Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр тавьж буй үндсэн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд 2025 онд компанийн техник, технологи, эдийн засгийн нөөц бололцоог илүү үр ашигтайгаар удирдан зохион байгуулж ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА



Ё.ЭНХТӨР

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Дугаар 02/2025

2025-04-21

Улаанбаатар хот

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар тус компанийн 2024 оны санхүүгийн тайланд “Аяатакс аудит” ХХК-ийн хийсэн аудитын дүгнэлтийг сонсож, хэлэлцээд **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрсүгэй.
2. Аудитын дүгнэлтэнд дурьдсан зөвлөмжийг ханган биелүүлж ажиллахыг компанийн гүйцэтгэх удирдлага болон санхүүд даалгасугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА



[Handwritten Signature]
Э.ЭНХТӨР

**УЛААНБААТАР ХИВС ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Дугаар 03/2025

2025-04-21

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2025 оны үйл
ажиллагааы зардлын төсвийг
батлах тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн ТУЗ болон хороодын зардлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын санал хураалтын үр дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ болон хороодын 2025 оны үйл ажиллагааны зардлыг 88,020.0 мян. төгрөгөөр, /Хавсралт №1/ тогтоон баталсугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА



Ё.ЭНХТӨР



“Улаанбаатар хивс” ХК-ийн
хувьцаа эзэмшигчдийн
2025 оны 04-р сарын 21-ний өдрийн
хурлын тэргүүлэгчдийн
02/2025 тоот тогтоолын
Хавсралт №01

**ТУЗ-ийн 2025 оны үйл
ажиллагааны
зардлын төсөв**

№	Зардлын товч утга	Нийт дүн [₮]
1	<u>Цалин:</u> - 64,320 мян ₮ <u>Хурлын ирцийн нэмэгдэл:</u> - 19,200 мян. ₮	₮ 83,520,000.00
2	Бичиг хэрэгслийн зардал	₮ 500,000.00
3	Хэвлэл, телефон холбооны зардал	₮ 2,000,000.00
4	Бусад, сургалт, аттестатчилал	₮ 2,000,000.00
	Дүн	₮ 88,020,000.00